



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/64

Бор-Өндөр сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Бор-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2026 оныг “Боловсролыг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан дэд хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан багш нарын цахим ур чадварыг нэмэгдүүлэх сургалтын төлбөр болох 4,000,000 (дөрвөн сая) төгрөгийг Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зарцуулсугай.

2. Засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас зохих хууль дүрэм, журмын дагуу зарцуулахыг санхүүгийн албаны дарга /Э.Түвшинсайхан/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ОТГОНЦЭЦЭГ